

**УБ ТРАНС ХХК-н 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Батлав. Байгаль орчин аялал жуучлалын яамны хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга _____ / А.Энхбат /

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

УБ ТРАНС ХХК-ийн захирал _____ /Ж.Батбаяр /

**УБ ТРАНС ХХК-ийн 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР /2572923/

Хянасан:

Байгаль орчин аялал жуучлалын яамны хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газрын мэргэжилтэн _____ / П.Шинэцэцэг/

Боловсруулсан:

УБ ТРАНС ХХК-ийн Үйл ажиллагааны менежер _____ / Д.Үүрийнтуяа/

2023 он

**УБ ТРАНС ХХК-н 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

**ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД
ТУСГАХ АЖЛУУД**

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулга

1. Гаалийн хяналтын бүсийн танилцуулга
2. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга.
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт.
4. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ.

- Агаар
- Хөрс
- Хог хаягдал
- Усан орчин

1. Гаалийн хяналтын бүсийн товч танилцуулга.

УБ Транс ХХК нь Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд Монгол улсын стандартад нийцсэн, “Ачааны терминал” –ийг 2010 онд барьж ашиглалтанд оруулсан. 2014 оны 3-р улирлаас нийт 5 га Гаалийн Хяналтын бүс бүрэн ашиглалтанд орсон. Манай хяналтын бүс нэг дор 50 вагон ачаа ачих зориулалттай 2 салаа төмөр зам, КС маркын 40 тонны гүүрэн кран, 150 тонны авто пүү, 20 ба 40 футын контейнер, овор хүнд ачаа зөөх хүнд даацын автомашин техник хэрэгслүүд, 3 тонны авто өргөгчтэй. Задгай нурмаг ачаа ачиж буулгах зориулалттай нягтруулсан хөрс бүхий 8700 м.куб талбай, контейнер хүлээн авах, ачиж буулгах зориулалт бүхий 7500 м.куб талбай болон хашаа, харуулын байр, гэрэлтүүлэг, Гаалийн хяналт шалгалтын телекамераар тоноглогдсон. Гаалийн хяналтын бүс нь экспорт, импортоор орж ирж буй вагоноос чингэлэг, ачаа тээшийг буулган шалгаж, хадгалах, гаалийн хяналтан дор эргүүлэн ачихдаа жинлэж, лацдах, аж ахуй нэгж байгууллага, хувь хүнд хүлээлгэн өгөх үйл ажиллагааг явуулдаг болно.

2. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

Байршил: Монгол улсын төвийн бүсийн зүүн өмнөд хэсэгт хойд өргөргийн 46057'-47002', зүүн уртрагийн 1070 57'- 1090 04' байрладаг. Улаанбаатар хотоос зүүн өмнө зүгт 250 км-ийн зайд оршдог. Хойд талаараа Төв аймгийн Баянцагаан, Баян, Баянжаргалан сумдтай зүүн ба зүүн хойд хэсгээрээ Хэнтий аймгийн Дэлгэрхаан, Дархан сумдтай, баруун

**УБ ТРАНС ХХК-н 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

болон баруун өмнөд хэсгээрээ Дундговь аймгийн Баянжаргалан, Цагаандэлгэр, Говь-Угтаал сумдтай тус тус хиллэдэг.

Нутаг дэвсгэр: 5.5 мянган километр хавтгай дөрвөлжин нутаг дэвсгэртэй, дөрвөн аймгийн 10 гаруй сумдтай хиллэж авто болон төмөр замын сүлжээнд холбогдсон төвийн бүсийн томоохон аймгийн нэг юм

Байгалийн баялаг: Чойр уулын зүүн тал Сүмбэр уулын эргэн тойронд 1:50000, төмөр замын дагуу 1:200000 масштабтай хийгдсэн гидрогеологийн судалгааны ажлын дүнд тоосгоны шавар, хүрэн нүүрс, газрын тос, холимог металл болон эрдэс будгийн нөөцийг тогтоосон байна. Ер нь аймийн төвөөс 100 километрийн радиус дотор 30 гаруй төрлийн ашигт малтмалын орд, илэрц байдаг: хайлуур жонш /38 сая тонн/, холимог металл /1.1 сая тонн/, төмрийн хүдэр /13 сая тонн/, бал чулуу /200 мянган тонн/, хүрэн нүүрс /13 биллион тонн/. Улсын хэмжээнд томд орох Шивээ-Овоогийн нүүрсний уурхайтай. Жилдээ 2 сая тонн нүүрс олборловол 300 жилийн нөөцтэй.

3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Болзошгүй нөлөөлөлд хамрагдах байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн экологи, физик-химийн өөрчлөлт, нийгэм эдийн засаг гэсэн 3 үндсэн бүлэгт багцлан хувааж, тус бүрийг нь 10 үзүүлэлтээр магадлан загсаах аргаар судлав. Нөлөөлөлийг “сөрөг” (-), “нөлөөлөлгүй” (0), “эерэг” (+) гэсэн 3 зэргээр тогтоосон болно. Нийт 3 үзүүлэлтээр гаргасан судалгаанаас үзэхэд 5 үзүүлэлт эерэг дунд, 12 үзүүлэлт сөрөг бага, 1 эрчимтэй сөрөг нөлөөтэйг, 11 үзүүлэлт нөлөөлөлгүйг харуулж байна.

**УБ ТРАНС ХХК-н 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгтийн тайлбар: Болзошгүй нөлөөлөлийг магадлан жагсаах арга.

№	Болзошгүй нөлөөлөл	Нөлөөлөл (-,+,0)	Нөлөөлөлийн эрчим		
			Бага	Дунд	Эрчимтэй
	Газрын рельеф	0			
	Геологийн орчин	0			
	Байгалийн төрх	0			
	Ашигт малтмал	0			
	Хөрсний элэгдэл		-		
	Хөрсний биоценоз		-		
	Гадаргын ус	0			
	Гидробиологи	0			
	Ургамлын бүрхэвч		-		
	Бэлчээр	0			
	Агаарын чанар		-		
	Уур амьсгал	0			
	Хөрсний агуулга, үржил шим		-		
	Хөрсний бохирдолт		-		
	Хөрсний эвдрэл	0			
	Хурдас чулуулаг	0			
	Гүний усанд химийн бодис тархах		-		
	Гүний усанд металаар бохирдох		-		
	Гүний усны бактерлогийн бохирдолт		-		
	Ургамлын аймаг		-		
	Усан хамгамж		-		
	Эрчим хүч		-		
	Зам			+	
	Харилцаа холбоо			+	
	Ажлын байр нэмэгдүүлэх			+	
	Ядуурлыг бууруулах			+	
	Хүнс тэжээлийн хангамж, үнэ			+	

**УБ ТРАНС ХХК-н 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

	ханшны өөрчлөлт				
	Палеонтологи, археологи, түүх соёлын дурсгалт зүйлс	0			
	Хүн амын эрүүл ахуй, орчны ариун цэвэр		-		
	Гэнэтийн аюул осол				-
	Дүн	11	12	5	1

4. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Байгаль орчин менежментийн төлөвлөгөөний гол зорилго нь гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллүүдийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүд нь дараахи зорилгуудыг хэрэгжүүлэхэд оршино. Үүнд :

- Агаар, хөрсөн бүрхэвч, ургамал болон тухайн орчинд амьдарч, ажиллаж буй хүмүүст гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөнүүдийг багасгах, бууруулах, арга хэмжээг тогтоох
- Ногоон байгууламжыг нэмэгдүүлэх, тоосжилтыг бууруулахад зориулсан үйлчилгээнүүдийг хийх
- Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх явцад мөрдөх эрх зүйн баримт бичгийг тодорхойлох
- Шаардлагатай хөрөнгө зардлыг урьдчилсан байдлаар тооцож тодорхойлох зэрэг орно.

УБ ТРАНС ХХК-н 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1.	Агаарын чанар	Тоосжилтыг бууруулах зорилгоор усаар шүршиж тоосыг дарах	Гаалийн талбай			тогтмол	Байгууллагын дотоод төлөвлөлт	2023 он	Агаарын тухай хууль, агаарын бохирдлын тухай хууль MNS4585:2016
		Төслийн талбайд тээврийн хэрэгслийг асаалттай байлгахгүй байх	Гаалийн талбай			тогтмол	Байгууллагын дотоод төлөвлөлт	2023 он	Техникийн ерөнхий шаардлага, MNS5885:2008
		Хар тугалганы агууламж багатай түлш хэрэглэх, техникийн норм мөрдөх.	Гаалийн талбай			тогтмол	Байгууллагын дотоод төлөвлөлт	2023 он	Техникийн ерөнхий шаардлага, MNS5885:2008

УБ ТРАНС ХХК-н 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2.	Гадар- гын ба газрын доорхи усны нөөц	Гүнийн худгийн тоног төхөөрөмжийн эрүүл бүсийн арчилгаа хамгаалалт	Гүнийн худагт	1ш			400.000төг	2023 оны 8-р сард	Ундны ус эрүүл ахуйн шаардлага, түүнд тавигдах хяналт MNS 0900:2015
		Унд-ахуйн худагны тоолуур арчилгаа, эвдрэл гэмтлийг засах, сэлбэх, шаардлагатай тохиолдолд солих	Хяналтын бүсд	2ш			600.000 төг	2023 оны 8-р сард	Ус ашиглалт хэрэглээг тоолууржуулах журам, Усны тухай хууль, Ундны ус эрүүл ахуйн шаардлага, түүнд тавигдах хяналт MNS 0900:2015
		Борооны ус ашиглан ногоон байгууламжийг усалгаажуулах	Усны нөөц ногоон байгуулам-жид ашиглах				Байгуулла-гын дотоод төлөвлөлт	2023 он Хур тундастай үед	
		Агаар, хөрс, усны хүнд металлын шинжилгээ хийлгэх	Хяналтын бүс				Батлагдсан тарифын дагуу	2023 оны 9-р сард	Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторид хийлгэх

УБ ТРАНС ХХК-н 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3.	Хөрсөн бүрхэвч	Хөрсийг элдэв бохирдлоос хамгаалах. /хяналтын бүсийн ачилт буулгалтын талбайн хатуу хучилттай хэсгийн эвдрэл гэмтлийг засах, сайжруулах/	Гаалийн хяналты талбайн үүдэн хэсэг	Тухайн гэмтэлтэй хэсгийг			Гэмтэлтэй хэсэгт таарах хэмжээгээр хийж гүйцэтгэнэ	2023 оны 10-р сард	Хөрс цөлжилтөөс хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Ариун цэврийн тухай хууль MNS6260:2011
4.	Газрын хэвлий	Талбайн орчинд олон салаа зам гаргахгүй нэгдсэн сүлжээтэй болж тэмдэг тэмдэглээг сайжруулах	Гаалийн талбайн гаднах замын маршрут	5ш	100.0 төг		100.000төг	2023 оны 9-р сар	Хөрс цөлжилтөөс хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Ариун цэврийн тухай хууль MNS6260:2011
		Нурмаг ачааны талбайг хатуу хучилттай болгож бетонжуулах.	Гаалийн хяналтын бүсийн нурмаг ачаа буулгадаг хэсэгт	2020-2022 онуудад нийт 3000м2 газрыг хатуу хучилттай болгосон. /доор зургийг оруулав/	5.000.0 төг		5.000.000 төг	2023 оны 10-р сард	Хөрс цөлжилтөөс хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Ариун цэврийн тухай хууль MNS6260:2011

УБ ТРАНС ХХК-н 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

		Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг хийлгэх заалтын дагуу					4.500.000 төг	Тухайн ажлыг хийлгэхээр мэргэжлийн байгууллага д хандан гэрээгээ хийсэн болно.	“Их монголын байгаль” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан.
		Нурмаг ачааны тоосжилтоос хамгаалах хашаа барих	Гаалийн хяналтын бүсийн хашаан дээгүүр.				Тухай бүрд байгууллагын санхүүгээс хамаарна	2023 оны 10 дугаар сараас барьж эхлэхээр төлөвлөж байна.	
		Байгаль орчны аудит хийлгэх	Гаалийн хяналтын бүсэд	1 удаа	4.000.0төг	2 жилд нэг удаа	4.400.000 НӨАТ-тай үнэ	2023 оны 10 дугаар сард	

УБ ТРАНС ХХК-н 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

5.	Ургамлан нөмрөг	Төслийн нутаг дэвсгэр ургамлан бүрхэцийн талхагдалд орсон талбайг нэмэгдүүлэхгүй байх зорилгоор Гаалийн хяналтын бүсийн оффисын байрны гадаа задгай талбайд мод, сөөг, олон наст болон нэг наст ургамал тарьж ургуулах	Гаалийн хяналтын бүсийн оффисын байрны гадаа задгай талбайд				2.000.0 төг	2023 оны 9-р сард тарьсан	Газрын тухай хуулийн 56.6 дахь заалтыг үндэслэн
6.	“Тэр бум мод” төслийн хүрээнд мод тарих	Говьсүмбэр аймags Сүмбэр сумын нутаг дэвсгэрт ЗДТГ-аас заасан байршилд мод тарих /жил бүр 270ш буюу нийт 5 жилийн хугацаанд 1350 ширхэг мод тарих/	Гомбосүрэн ноёны цэцэрлэгт хүрээлэнд 2023 онд 2700 ширхэг мод тарих тухай сумын ЗДТГ-с чиглэл өгсөн.				3.000.0 төг	2023 оны 10 дугаар сарын 15,16нд	Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Засаг даргын 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн А/66 тоот захирамжыг үндэслэн
	Нийт						20.000.0төг		

УБ ТРАНС ХХК-н 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

6.Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Гаалийн хяналтын бүсийн оффисын байрны гадаа талбайд тод тарьж ургуулах	Жил бүрийн хавар	Бүх ажилчид оролцох	Ширхэг /мод/	50ш хайлаас	10.0т	500.0 төг	2023 оны 10 дугаар сард	Газрын тухай хууль, эвдэрсэн газрыг ургамалжуулах,
2.	Гаалийн хяналтын бүсийн хойд хэсэгт мод тарьж ургуулах	Жил бүрийн хавар	Бүх ажилчид оролцох	Ширхэг /мод/	20ш улиас	10.0т	200.0 төг	2023 оны 10 дугаар сард	
					Хар шороо 2 машин	160.0 т	320.0 төг	2023 оны 10 дугаар сард	
3.	Туурь хог хаягдал цэвэрлэх, нүх шуудууг түрж тэгшлэх	Шаардлагатай цаг үед	ГХБ-н ажилчид		Улиралд 1 удаа	400.0т	1.600.0 төг	Улирал бүр	Нийгмийн болон хүрээлэн буй орчныг хамгаалах, хариуцлагын хүрээнд
	Нийт						2.620.0 төг		

УБ ТРАНС ХХК-н 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар болон археологийн ба палентлогийн олдвор одоогоор тохиолдоогүй. Цаашид үйл ажиллагааны явцад түүх соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн 1-р бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтанд байна” гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судлаж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллах болно. Соёлын ба үнэт өв зүйлсийг илрүүлж, тэр нь төслийн үйл ажиллагаанд эрсдэхээр байвал орон нутгийн засаг даргаас энэ үйл ажиллагааг даруй зогсоохыг шаардах, бололцоотой бол эдгээр газруудыг аль болох зохистойгоор хамгаалахыг хуульд заасан байдаг. Боловсрол, Соёл, ШУ-ны яамны тусгай зөвшөөрөлгүйгээр зөөж шилжүүлэх боломжгүй соёлын ба үнэт дурсгалын өвийг малтах, зөөх, эвдэхийг хуулиар хориглосон байдаг.

8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Ахуйн	Хог түр хадгалах цэгт төвлөрсөн хогийг зөвшөөрсөн цэгт зөөж зайлуулах	Талбайн хэмжээнд			Сард 2 удаа тогтмол хийгддэг ажил	Байгууллагын дотоод төлөвлөлт	2023 он	Хог хаягдлын тухай хууль

УБ ТРАНС ХХК-н 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

		Ил задгай хог хаяхгүй байх талаар анхааруулга санамж бүхий самбар, тэмдэгжүүлэлттэй болох	Талбайн хамжээнд	ш	30.0 төг	4ш	120.000 төг	2023 оны 9-р сард	Хог хаягдлын тухай хууль
		Гаалийн хяналтын бүс доторхи болон гадна талбайн ойр орчмын хогийг түүж цэвэрлэх	Хяналтын бүс дотор			Сар бүр	Байгууллагын дотоод төлөвлөлт	2023 он	Хог хаягдлын тухай хууль
		Гаалийн хяналтын бүсийн хашаанд хогийг ангилан хаях хогны сав авч байршуулах	Хяналтын бүсийн хашаанд				1.500.0 төг	2023 оны 9 сард	Хог хаягдлын тухай хууль
		Оффис доторх боловсон бие засах газрын бохирыг соруулах	Оффис дотор		1 удаагийн соруулалт 195.0 төг	Жилд 2 удаа	390.000 төг	2023 он	Хог хаягдлын тухай хууль
2.	Үйлдвэрийн	-							
3.	Аюултай	-							

УБ ТРАНС ХХК-н 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	Нийт						2.010.000 төг	
--	-------------	--	--	--	--	--	----------------------	--

9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1.	Орчны хөрсөн дэх эмгэг төрүүлэгч бактерийн тоо	Төслийн талбайд хог хаягдлын цэг	Жилд нэг удаа	1	25.0 төг	25.0 төг		Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд
2.	Ундны усан дахь эмгэг төрүүлэгч бактерийн тоо	ГХБ-н худагт	Жилд нэг удаа	1	50.0 төг	50.0 төг		Хүнд элементийн шинжилгээ
3.	Ундны усны бүрэн шинжилгээ	ГХБ-н худагт	Жилд нэг удаа	1	50.0 төг	50.0 төг		Ерөнхий хими
4.	Ундны усан дахь хүнд металлын агууламж	ГХБ-н худагт	Жилд нэг удаа	1	50.0 төг	50.0 төг		Хүнд элементийн шинжилгээ
	Нийт					175.0 төг		

УБ ТРАНС ХХК-н 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2023 он				
			Сар ...	Сар ...	Сар ...		
1	2	3	4	5	6	7	
1.	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний хүрээнд мод тарих	2.620.000 төг	08/30	08/31	09/01	Үйл ажиллагааны менежер	
2.	Сөрөг нөлөөлөлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд ажлуудыг хийж эхлүүлэх	20.000.000төг	Боломжит хугацаанд	Боломжит хугацаанд	Боломжит хугацаанд	Үйл ажиллагааны менежер	
3.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд ажлуудыг хийж эхлүүлэх	2.010.000 төг	Тухай бүрд	Тухай бүрд	Тухай бүрд	ГХБ-н эрхлэгч	
4.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд ажлуудыг хийж эхлүүлэх	175.000 төг	Заагдсан хугацаанд	Заагдсан хугацаанд	Заагдсан хугацаанд	Үйл ажиллагааны менежер	
	Нийт	24.805.000 төг					

УБ ТРАНС ХХК-н 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1.	Хяналтын бүсийн ажилчид, захиргаа алба, хяналтын бүсийн үйлчлүүлэгч нар, оршин суугч нар	Зөвлөгөөн хийх	2023 оны БОМТ-г танилцуулах, үүнтэй холбоотой хийгдсэн ажлуудаа тайлагнах	Оны эцэст буюу 12-р сарын боломжит өдөр	200.0 төг	ГХБ-н эрхлэгч болон захиргаа аж ахуйн алба	Чойр дахь гаалийн хяналтын бүсийн оффисд
2	2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хийж бэлдэж Говьсүмбэр аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарт тайлагнах, хамгаалах	Төлөвлөгөөний тайлангийн үзүүлэн (presentation) тавьж батлуулна.	2023 онд байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулахад зориулж хийгдсэн ажлуудыг тайлагнах	Говьсүмбэр аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас тогтоосон хугацаанд	300.0 төг	ҮАМенежер Д.Үүрийнтуяа	Говьсүмбэр аймаг
3	Батлуулсан 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлангийн биелэлтийг 2024 оны	2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг бичиж хүргүүлэх	2023 онд хийгдэх ажлууд, түүнд зориулж батлагдсан төсвийн хамт.	2024 оны 1 дүгээр улиралд	100.0 төг	ҮАМенежер Д.Үүрийнтуяа	Улаанбаатар хот

УБ ТРАНС ХХК-н 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй хамт Байгаль орчин, аялал жуучлалын яаманд хүргүүлэн батлуулах							
Нийт					500,0 төг		

2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **25.405.000** төгрөгний төсөв зарцуулахаар төсөвлөсөн байна. Мөн байгууллагын дотоод төлөвлөлтөөр хийгдэх ажлууд энд тусгагдаагүй болно.

2020-2022 онуудад хяналтын талбайн нийт 3000м2 талбайг хатуу хучилттай болгосон.




УБ ТРАНС ХХК-н 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



УБ ТРАНС ХХК-н 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Гаалийн хяналтын бүсийн оффисын барилга дотор боловсон бие засах газартай ба жил бүр Сүмбэр сумын “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-аар бохирыг нь соруулдаг болно.



УБ ТРАНС ХХК-н 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



УБ ТРАНС ХХК-н 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



УБ ТРАНС ХХК-н 2023 онд ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Анхаарал тавьсанд баярлалаа
2023 он